

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ ГАРАХАД ЖОЛООЧИЙН ЗАН ҮЙЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

A STUDY ON THE IMPACT OF DRIVER BEHAVIOR ON TRAFFIC ACCIDENTS AND VIOLATIONS

Баатарын Оюутболд*, Батхүүгийн Болд

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Oyutbold Baatar, Bold Batkhuu, MA Scholar, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: b.oyut2015@gmail.com

Хураангуй: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас гаргасан тайланд 2016 онд зам тээврийн ослоор өдөрт дунджаар 3700 хүн нас барж, дэлхий даяар жил бүр 1.35 сая хүн зам тээврийн ослоор нас бардаг болохыг тогтоожээ. Харин Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлийн тоо, түүнээс учирч байгаа хохирлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр байна. Тиймээс шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийж, жолоочоос шалтгаалах хүчин зүйлийг бууруулах хэрэгцээ шаардлага байна. Өөрөөр хэлбэл, зам тээврийн осол, зөрчил гарахад жолоочийн түрэмгий болон бусад зан үйлийг тодорхойлсноор зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Энэхүү сэдвийн хүрээнд жолоочийн зан үйл, зан төлөвийг харьцуулан үзэж, түүний онолын асуудлыг гадаадын болон дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлээс тоймлон судалж, монгол жолоочийн зан үйлийн талаар судлагдсан байдалд дүн шинжилгээ хийж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх боломжийг судалж үзлээ.

Судалгааны үр дүнгээр Монгол Улсад жолоочийн зан үйлийг судалсан бүтээл ховор болох нь судалгаанаас харагдаж байна. Тиймээс энэ чиглэлийн судалгааг эхлүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Учир нь зам тээврийн осол, зөрчлийн гаралт жолоочийн буруутай үйлдлээс шууд шалтгаалж байгаа талаар цагдаагийн байгууллагаас жил бүр мэдээлсээр байгаа тул жолоочийн буруутай үйлдлийн гол шалтгааныг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах арга замыг оновчтой авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Abstract: According to a report by the World Health Organization (WHO), in 2016, an average of 3,700 people died daily due to road traffic accidents, with 1.35 million people losing their lives globally each year in such incidents. In Mongolia, the number of road traffic accidents and violations, as well as the extent of the damage, have been steadily increasing. Therefore, there is a need to analyze the causes and factors behind these incidents, and reduce the role of driver-related factors. In other words, by identifying aggressive and other dangerous behaviors of drivers, it will be possible to reduce and prevent road traffic accidents and violations.

Within the framework of this topic, a comparison of driver behavior and attitudes was conducted, reviewing the theoretical aspects of this issue in works by both domestic and international scholars. The research also examined the studies on the driving behavior of Mongolian drivers and explored ways to prevent road traffic accidents.



Урьдчилан сэргийлэх





The research findings show that studies on driver behavior in Mongolia are limited. Therefore, it is essential to initiate and develop research in this area. This is particularly important because, as reported by law enforcement annually, road traffic accidents and violations are often directly caused by the wrongful actions of drivers. By identifying the main causes of these wrongful behaviors, it will be possible to implement targeted preventive measures to reduce and mitigate road traffic accidents.

Түлхүүр үгс: Зан үйл, жолоочийн зан үйл, зам тээврийн осол, зөрчил, урьдчилан сэргийлэх ажил.

Keywords: Behavior, Driver Behavior, Traffic Accidents, Violations, prevention.

Удиртгал

“Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэдэг нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг” хэлнэ гэж заасан. Монгол Улсад зам тээврийн осол 2018 онд 29474, 2019 онд 25302, 2020 онд 21768, 2021 онд 224828, 2022 онд 24121, 2023 онд 25235, 2024 онд 30977 зам тээврийн осол тус тус бүртгэгджээ. Эндээс харахад 2024 онд бүртгэгдсэн зам тээврийн ослыг 2023 онтой харьцуулахад 22.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна (ТЦА, 2024).

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас гаргасан тайланд 2016 онд зам тээврийн ослоор өдөрт дунджаар 3700 хүн нас барж, дэлхий даяар жил бүр 1.35 сая хүн зам тээврийн ослоор нас бардаг болохыг тогтоожээ. (WHO, 2018).

Гадаадын зарим улсад дижитал технологиос цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зам тээврийн осол, түгжрэл, зөрчил зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлийг (Kumar et al., 2017, p. 5) шийдвэрлэх зорилготойгоор технологид суурилсан системийг ашигладаг. Жишээлбэл, жолоочийн тусламжийн систем (ADAS) нь жолооч нарт аюулгүй байдлыг хангахад тусалж,

ослын эрсдэлийг бууруулах, жолоодлогыг илүү тухтай болгох зэргээр туслах зорилготой тээврийн хэрэгслийн дижитал технологийн жишээ юм.

ADAS технологи нь замын эгнээнээс гарахад өгөх анхааруулах дохио, автомат яаралтай тоормос, ухрах камер гэх мэт функцуудыг багтаасан технологи юм. (Advanced Driving Assistance Systems (ADAS), 2025). Эдгээр системүүд нь ихэвчлэн мэдрэгч, камер, радар болон бусад технологийг хослуулан ашигладаг бөгөөд тээврийн хэрэгсэл болон түүний эргэн тойрон дахь мэдээллийг цуглуулж, шаардлагатай бол жолоочид сэрэмжлүүлэг өгдөг технологи юм. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан, машин сургалтын, COVID-19 оношилгооны болон бусад технологийг өөр өөр нөхцөлд өргөн хэрэглэгддэг байна. Эдгээр техникүүд нь тээврийн хэрэгслийн ухаалаг системийг хөгжлийг хурдасгаж, ялангуяа замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан таамаглах, илрүүлэх (Peng et al., 2020), ангилах болон бусад замын хөдөлгөөний асуудлуудыг илүү үр дүнтэй болгодог.

Зам тээврийн осол, зөрчил гарахад жолоочийн буруутай үйлдэл, замын нөхцөл байдал, хүрээлэн буй орчноос шалтгаалдаг. Үүнээс жолоочоос шалтгаалсан зам тээврийн

осол, зөрчил 97-оос дээш хувийг эзэлдэг. Тиймээс жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчилд дүн шинжилгээ хийж, хүний хүсэл зоригоос шууд хамаарах шалтгааныг тодорхойлох, жолоочийн зан үйлд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай юм.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын дийлэнх хувийг хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл буруу хийсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдлүүд эзэлж байна. Эдгээр үйлдлүүдийг гаргахад жолоочийн зан үйлийн харилцан хамаарлыг судалж, дүн шинжилгээ хийх нь зам тээврийн осол, зөрчлийг бууруулах стратеги боловсруулахад чухал ач холбогдолтой.

Энэхүү өгүүллийн зорилго нь жолоочийн зан үйл гэсэн ойлголтыг харьцуулан судалж, монголд жолоочийн зан үйлийн талаар судалсан бүтээлийг тоймлон үзэж, энэ чиглэлийн судалгааны агуулгад дүн шинжилгээ хийж, цаашид хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход чиглэнэ.

Уг судалгааны ажилд зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл, жолоочийн зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлийг харьцуулах, тоо баримтад дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргуудыг түлхүү хэрэглэсэн болно. Эдгээр аргаас гадна зам тээврийн осол, зөрчлийн статистик тоон мэдээг үндэслэн тухайн үзэгдлийг тайлбарлаж, дүн шинжилгээ хийх, жолоочийн зан төлөвийн талаарх ойлголтыг гадаадын зарим орны болон дотоодын эрдэмтдийн бүтээлийг харьцуулан судаллаа.

Үндсэн хэсэг

Бид судалгааны ажлынхаа хүрээнд судлагдсан байдлын тоймыг авч үзэхдээ нэгт; зан үйл, зан төлөвийн тухай ойлголтыг ерөнхий сэтгэл судлалын шинжлэх ухаанд хэрхэн тайлбарласныг, хоёрдугаарт, гадаадын судлаачдын бүтээлд жолоочийн зан үйлийг судалсан байдлыг, гуравдугаарт; Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал, жолоочийн зан үйл хэрхэн нөлөөлж байгааг судалсан бүтээлийн тоймыг авч үзнэ.

Нэг. Зан үйл, зан төлөвийн талаарх судалгаа. Монгол Улсад ерөнхий сэтгэл судлалын болон бусад мэргэжлийн тухайлбал, хууль зүйн сэтгэл судлал бүтээлүүдэд хүний зан үйл, төлөвийг тодорхойлон авч үзсэн цөөнгүй бүтээлүүд байна. Тухайлбал, Ерөнхий сэтгэл судлал бүтээлд хүнийг амьтадаас ялгаж байдаг олон шинжүүд байх бөгөөд тэдгээрийг сэтгэцийн шинж гэсэн бүлгийг хамааруулж үздэг. Бидний ухамсар, оюун санаанд шингэн, хийж буй үйлдэл, хөдөлгөөн бүрд, ахуй амьдралын янз бүрийн нөхцөлд илрэн гарч байдаг олон шинж чанаруудыг сэтгэцийн шинж гэнэ. Сэтгэцийн шинжид зан төлөв, темперамент, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж, авьяас чадвар, зоригийн процессуудыг багтаана.

Зан төлөв гэдэг нь хувь хүний онцлог, үзэл бодол, харилцаа хандлага, үйл хэрэг, түүний үйлдэл, амьдралын янз бүрийн нөхцөл, үйл явдалд хариу үзүүлэх үндэс болж байдаг бие хүний тогтвортой шинжүүдийн цогц бүрдэл. Харин зан үйлийн хэлбэр нь хүний бие махбодоос хариулах үйлдлийн цогц гэжээ (Батсайхан & Дэлгэржав, 2013).

Харилцааны сэтгэл судлал бүтээлд ... хүний үйл хөдлөл, харилцааны явцад илрэн гарч байгаа сэтгэл зүйн онцгой шинжүүдийн цогц (Оюундалай & Балжинням, 2017) юм.





МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ

Темперамент дээр үндэслэн хүмүүжил, төлөвшлийн үр дүнд бий болдог, хандлага нь ... харилцагчдын зан байдал, үг яриа, сэтгэл хөдлөл зэргээр дамжин гаднаа илэрдэг, тухайн хүн өөртөө, бусдад нийгэмд хандах зан үйлийн шинж гэж тайлбарлажээ.

“Сэтгэл зүйд өөрөө суралцах нь” бүтээлд зан үйлийг хөдөлгөгч хүч нь хүнд байгалиас заяасан зөн билэг, хүмүүжлийн нөлөөгөөр олж авсан үзэл санаа байдаг. Зан үйлийн бодит чиг хандлага үндсэндээ түүний олж авсан дадал, зуршлаас шалтгаална. Мөн бие хүний сэтгэл хөдлөл мэдрэмжийн хөгжил хэд хэдэн чиглэлээр өрнөх боломжтой юм. Нэгдүгээрт, сэтгэл хөдөлгөөний нөлөөгөөр үүссэн хүний бодол, сэтгэгдлийн шинэ чиглэл, эд юмс, үйл явдал, хүмүүс рүү хандуулах замаар агуулга, нөлөөллийг тэлж, өргөтгөн хөгжүүлэх боломж бий, Хоёрдугаарт, хүний ухамсрын үйлийн зохицуулалт, зоригийн оролцоог нэмэгдүүлэх замаар өөрөө өөртөө хяналт тавих, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах арга барилд суралцах, Гуравдугаарт, сэтгэл хөдлөлийн хүрэн дэх зан үйлийн зохицуулалтыг аажмаар нэмэгдүүлэх зорилгоор өндөр хэмжээнд ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйлс, үүрэг хариуцлага, хүнлэг чанар, шударга зан зэрэг бие хүний онцгой чанаруудыг төлөвшүүлнэ ... гэжээ (Доржжав, 2005).

Мөн Хууль зүйн сэтгэл судлал бүтээлд “зан төлөв бол амьдралын тодорхой нөхцөлд хүний зан үйлийн өвөрмөц онцлог, хэв маягийг тодорхойлогч чанаруудын цогц бүрдэл” юм (Жанцан, 2024) гэж тодорхойлжээ. Тэрээр хүний зан төлөвийг бие хүний дасан зохицох аргыг харгалзан дараах байдлаар ангилсан. Үүнд: 1) Хүрээлэн буй орчинтойгоо түргэн дасах чадвартай хэв шинж, 2) дотооддоо зөрчилтэй хэв шинж, гэвч орчинтойгоо гадна талаас нь зохицох хэв шинж, 3)

дасан зохицох чадвар султай, зөрчилтэй хэв шинж, 4) тогтвортой бус байр суурь, зарчимч биш байдлынхаа үр дүнд орчинтойгоо гаднах байдлаараа дасан зохицох чадваргүй зэрэг хэв шинжүүдэд хуваажээ.

Эдгээр бүтээлүүдийг харьцуулан үзэхэд сэтгэл судлалын шинжлэх ухааны хүрээнд зан үйл, зан төлөвийн тухай ерөнхий ойлголтуудыг авч үздэг.

Сэтгэл зүйн шинжлэх ухааны онолын эх суурь нь бихевиоризм, психоанализ, гештальт, когнитивзм, интеракционизм гэсэн чиглэлд тулгуурласан. Тухайлбал, зан үйлийн онол буюу бихевиоризм (behavior-зан үйл)-ын онолын гол төлөөлөгчид Дж. Уотсон, Э.Торндайк, К. Халл, Б.Скиннер бөгөөд хүний гаднын хүчин зүйлд (үг ба хөдөлгөөний цогц байдлаар) хариулахад нийгмийн өдөөн түлхэгч урамшуулагч нь бусад хүмүүс гэж үздэг.

Бид судалгааны хязгаарлалтын хүрээнд “жолоочийн зан үйл”-ийг судалж үзэх бөгөөд бихевиоризмын онолд тулгуурласан байх бөгөөд англи хэлнээ “driver behavior” гэсэн агуулгын хүрээнд судлагдсан байдлын тоймыг авч үзнэ.

Хоёр. Гадаадын зарим судлаачдын бүтээлийг тоймлон үзэх нь. Жолоочийн зан үйлийг тав ангилж авч үзэх бөгөөд үүнд үндэслэн зарим бүтээлийг тоймлон авч үзье. Үүнд:

1) Жолоочийн хэвийн бус зан үйл, (Зам дээрх аюултай болон эрсдэлтэй зан үйлүүд, энэ нь жолооч, зорчигч, бусад жолоочийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй); 2) Жолоочийн тэвчээргүй, түрэмгий үйлдэл (хурд хэтрүүлэх, хэт ойрхон явж, дагаж явах, эсхүл бусад бүдүүлэг зан үйлүүд); 3) Зам дээрх шугамаас хазайх (line deviation, замынхаа хязгаараас хазайж, өөрийн эгнээний шугамаас гарч явах буюу энэ нь

анхаарал сул эсхүл удирдлагагүй байгааг илэрхийлж болно); 4)Тээврийн хэрэгслийг хяналттай зогсоол, уулзвар дээр зогсооход жолоочийн биеэ авч яваа байдал (зогсоол, уулзвар дээр хэрхэн зогсож байгаагаар илэрнэ. Жишээлбэл, уулзвар дээр зогсоохгүй өнгөрөх, хурдтай зогсох зэрэг зан үйлүүд орно); 5)Жолоочийн нөхцөл байдал (жолоочийн анхаарал сарнисан, ядарсан эсхүл архи, мансууруулах бодис хэрэглэсэн байдал зам дээр аюулгүй жолоодох чадварт нөлөөлдөг) гэж ангилан авч үздэг (Soukaina et al., 2023).

Жолоочийн зан үйл нь олон хүчин зүйлийн нөлөөтэй, нарийн төвөгтэй ойлголт бөгөөд үүнийг зөв тайлбарлах, дүн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байдаг. Эдгээр хүчин зүйлд сэтгэл зүй, нийгэм, соёл, хүрээлэн буй орчны нөлөөлөл, мөн жолоочийн хувь хүний онцлог шинж чанарууд байдаг.

Жолоочийн зан үйлийг ойлгохын тулд жолооч, машин, хүрээлэн буй орчны хоорондын хамаарлыг судлах шаардлагатай. Тиймээс дараах гурван нөхцөл байдлыг авч үзэх шаардлагатай (Soultana et al., 2019). Үүнд: жолоочийн өөрийн нөхцөл байдал, хурд, хурдатгал зэрэг машины контекст, замын хөдөлгөөний нөхцөл зэрэг болно. Жишээлбэл, замын нөхцөл байдалд замын геометр, саад бэрхшээл, цаг агаарын нөхцөл зэрэг хүрээлэн буй орчны нөхцөл байдал хамаардаг.

Мөн жолоочийн хэвийн бус зан үйлийг жолоодлого хийж байгаагаар нь тодорхойлоход замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гол хэрэгсэл болдог. “Замын хөдөлгөөний камер ашиглан тээврийн хэрэгслийн хэвийн бус үйлдлийг илрүүлэх нь” судалгаанд замын хөдөлгөөний камер болон видео дүрсээр тодорхой объект илрүүлэхийн тулд (YOLO) алгоритмыг ашиглан

жолоочийн хэвийн бус байдлыг илрүүлэх бодит системийг судалсан байна. (Wang et al., 2019, хууд. 125-136).

“Машин сургалтыг ашиглан жолоочийн зан үйлийг тодорхойлоход өгөгдөлд суурилсан тогтолцоог ашиглах нь” бүтээлд тээврийн хэрэгслийн байршлыг хянах ба тодорхой хэвийн бус нөхцөл байгааг илрүүлэхэд тээврийн хэрэгслийн зургуудыг (хурднаас нь хамаарч) ашиглан гүйцэтгэдэг (Abdelrahman et al., 2020). Энд хурдны замын судалгааны хөтөлбөр-2 (SHRP 2) болон Байгалийн нөхцөлд явуулсан жолоодлогын судалгаа (NDS)-ны датаг ашиглан жолоочийн эрсдэлийн профайлыг үнэлдэг бөгөөд Random Forest (RF) алгоритм ашиглан 90% нарийвчлалтай.

Мөн зарим бүтээлүүдэд жолоочийн зан үйлийг эерэг ба сөрөг гэж ангилсан. Тухайлбал, “Аюултай жолоодлогыг илрүүлэх программ ба түүнтэй холбоотой тоглоомын хүрээ” бүтээлд (Bahadoor & Hosein, 2016) жолоочийн сөрөг зан үйлийг илрүүлэх, хэрэглэгчдийг жолоочийн аюулгүй байдлыг хангахад түлхэц өгөх хоёрын хоорондох зайг холбосон “Project Drive” нэртэй гар утасны программыг дамжуулж, GPS-ийн өгөгдөл дээр кластерын k-means алгоритмыг ашиглаж, судалгааг явуулсан. Мөн замын тэмдэг байгаа эсэх нь симулятор болон камерын өгөгдлийг ашиглан шөнийн цагаар залуу жолооч нарын зан төлөвт хэрхэн нөлөөлдөг талаарх судалгааг хийж, зохиогчид симуляторын өгөгдөл болон MANOVA статистикийн техникийг ашиглан хөдөө орон нутгийн хоёр эгнээтэй зам дээр эргэлт хийх үед жолоочийн зан байдал хэрхэн нөлөөлөхийг судалжээ (Awan et al., 2019).

Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах





МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАХ
САНГАА

чиглэлээр олон эрдэмтэн судлаачдын бүтээлийг дурдаж болно. Үүнд: “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” (Энхболд, 2008) бүтээлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай ойлголт, түүнийг зохицуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал, хөдөлгөөнд оролцогчдын сэтгэл зүйн байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг, “Замын хөдөлгөөний аюулгүйн үндэс” (Дүгэрээ & Каукен, 1992) бүтээлд тээврийн хэрэгслийн техникийн байдлыг замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх талаас нь, “Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх криминологийн шинж чанар” сэдэвт бүтээлд зам тээврийн ослын криминологи шинжийг түүхэн талаас нь судалж, хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдал, эрсдэлийн нийтлэг шинж чанараар нь судалж, дүн шинжилгээ хийжээ (Нямдорж, 2009) г.м.

Доктор Ч.Жаргалсайхан жолооч бэлтгэх сургалтын байдалд дүн шинжилгээ хийж, жолооны бэлтгэлжилтийг төгөлдөржүүлэх талаар (Жаргалсайхан, 2002), доктор Т.Занашир замын хөдөлгөөнд саад болохуйц аюултай цэгүүдийг тооцоолон замын хөдөлгөөнд аюулгүй байдлыг хангаж оролцох талаар (Занашир, 1997), Р.Ринчиндорж замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлын талаас нь болон замын гадаргуугийн онцлогоос хамаарч тоормослолтын талаар судалжээ.

Магистрын судалгааны ажлыг түүвэрлэн үзвэл “Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих захиргааны хяналт” сэдэвт судалгааны ажилд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд захиргааны байгууллагаас тавьж буй хяналт, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй

асуудал (Баттөмөр, 2008), “Зам тээврийн ослын үед жолоочийн үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал” сэдэвт судалгааны ажилд тухай гэмт хэрэг нь хүний ухамсарт зан үйлийн илрэл бөгөөд гэмт хэрэгтэн бие хүнийг судалснаар нийгэм хүн ам зүйн, ёс суртахуун, сэтгэл зүйн чанаруудыг тогтоодог гэж үзээд ... жолоочийн мэдлэг ур чадвар муу байдал, хувь хүний ёс суртахууны доройтол, хотжих үйл явцтай холбоотой болох нь тогтоогдлоо гэж дүгнэсэн.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт судалгааны ажилд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай 1996, 2015 оны хуулийг харьцуулан судалж, холбогдох хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийжээ (Гэрэлмаа, 2014). Ингэхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээ, түүнийг эрх бүхий байгууллага хэрхэн хэрэглэх, тайлбарлах, практикт тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг санал болгожээ.

“Зам тээврийн хэрэг, ослын гаралтыг бууруулах ажлын удирдлага, зохион байгуулалт” (Ганхуяг, 2015) бүтээлд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүхэн хөгжил, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, зам тээврийн хэрэг, ослын шалтгаан нөхцөл, түүнийг бууруулах ажлыг зохион байгуулах онцлог, сайжруулах арга замыг судалж, мэргэжлийн удирдлагаар хангах, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар дүгнэжээ, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг

хангахад техник хэрэгслийг ашиглах нь” сэдэвт судалгааны ажилд техник хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад ашиглаж ирсэн түүхэн уламжлал, гадаадын зарим улсад хяналтын камер ашиглаж зам тээврийн осол, зөрчил гарч буй нөхцөл байдлыг судалжээ (Батболд, 2015).

Зам тээврийн осол хэргийн шалтгаан, түүний эрсдэлийн удирдлага (Мягмарсүрэн, 2017) бүтээлд зам тээврийн ослын хэргийн тухай ойлголт, эрсдэлт хүчин зүйл, түүнд хийсэн дүн шинжилгээ, түүнийг бууруулах арга замыг судалж, жолоочийн болон явган зорчигчийн буруутай үйл ажиллагаа, замын нөхцөл байдал нь осол, зөрчил гарахад нөлөөлж байгаа талаар, Зам тээврийн ослын нөлөөлөх хүчин зүйл болох нь (Эрдэнэхуяг, 2017) бүтээлд авто замын байгууламжийн үүсэл, хөгжил, эрх зүйн зохицуулалт, гадаадын зарим орны туршлага, зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, түүнийг боловсронгуй болгох талаар судалж, ... авто замын нөхцөл байдалд зам тээврийн осол гарахад нөлөөлж байгаа талаар дүгнэжээ, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэлээр нутгийн захиргааны байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ” (Чинзориг, 2017) сэдэвт судалгааны ажилд нутгийн захиргааны байгууллагаас гаргаж буй хэм хэмжээнүүд нь замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн хэрэгслийн автобусны эргэлтийн хугацаа ойртож, зорчих хугацаа багассан талаар статистик судалгаанд үндэслэн гаргажээ.

Тууш замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал (Гомбосүрэнжав, 2017) бүтээлд тууш замын тухай ойлголт, нэр томъёоны агуулга, гадаадын зарим

орны туршлага, замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих хяналт, түүний онцлог, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар, Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал (Батбаяр, 2017) бүтээлд тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл, түүний ангилал, эрх зүйн зохицуулалт, энэ төрлийн зөрчлийн шалтгаан, шийдвэрлэлтэд хийсэн судалгаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замын талаар судалжээ.

“Жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, хэргийг бууруулах арга зам” сэдэвт судалгааны ажилд жолооч хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн, хурд хэтрүүлсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, ... жолоочийн ёс суртахуун, сахилга бат, соёлын талаарх мэдлэг олгохгүй байгаа нь жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол гарах шалтгаан болж байна (Д.Мөнгөн, 2020) гэж дүгнэжээ. Мөн Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэж буй сургалтын шинжилгээ (Анхбаяр, 2022) бүтээлд “жолооч бэлтгэх сургалт чанартай зохион байгуулагдаж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдалд жолоочийн оролцоо (Жаргал, 2018), Жолоочийн сэтгэл зүй (Оюундалай et al., 2019) бүтээлд жолоочийн сэтгэл зүйн онцлог, жолооч-машин-зам-орчин систем дэх жолоочийн итгэлт байдал, сэтгэц физиологи ба жолоочийн үйл ажиллагааны талаар судалжээ. Мөн тэрээр жолоочийн бэлэн байдал, осол аваар гаргах шалтгаан, жолоочийн сэтгэл зүйд нөлөөлөх хүчин зүйл, осолд





МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД
2023 ОНД 25235 ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ
БҮРТГЭГДСЭНИЙ 21053 БУЮУ 83.4 ХУВЬ НЬ
НИЙСЛЭЛД, 4182 БУЮУ 16.6 ХУВЬ НЬ ОРОН
НУТАГТ БҮРТГЭГДЭЖ, ӨМНӨХ ОНООС 4.6
ХУВИАР ӨССӨН.

хүргэх сэтгэцийн хүчин зүйл, урьдчилан сэргийлэх арга зам, жолоочийн сэтгэл зүйд темперамент нөлөөлөх нь, сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүдийг авч үзжээ.

Дээрх судалгаанаас харьцуулан үзвэл замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай ойлголт, зам орчин, тээврийн хэрэгсэл, түүний бүрэн бүтэн байдал, жолоочийн үүрэг, хариуцлага, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт талаас нь авч үзсэн бүтээлүүд дийлэнх хувийг эзэлж байна. Харин жолоочийн сэтгэл зүй, зан үйл талаас нь судалсан бүтээлүүд ховор болох нь харагдаж байна. Тиймээс жолоочийн зан үйлийн талаар нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийж, зам тээврийн осол, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход ашиглах нь зүйтэй байна.

Гурав. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн өнөөгийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийж, жолоочийн зан үйлийг нөлөөлөх эсэхийг тодорхойлох боломжийг эрэлхийлнэ.

Монгол Улсын хэмжээнд 2023 онд 25235 зам тээврийн осол бүртгэгдсэний 21053 буюу 83.4 хувь нь Нийслэлд, 4182 буюу 16.6 хувь нь орон нутагт бүртгэгдэж, өмнөх оноос 4.6 хувиар өссөн.

Монгол Улсын хэмжээнд 2023 онд 25235 зам тээврийн осол бүртгэгдсэний 21053 буюу 83.4 хувь нь Нийслэлд, 4182 буюу 16.6 хувь нь орон нутагт бүртгэгдэж, 2022 оноос 4.6 хувиар өссөн.

Харин 2024 онд зам тээврийн осол улсын хэмжээнд нийт 30977 буюу өмнөх оноос 22.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 1. Бүртгэгдсэн зам тээврийн ослын мэдээ

Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01- ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 7.334.349 зөрчилд шийтгэл оногдуулжээ (Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга. , 2021). Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар 31 байгууллагын 216 орчим нэгжид хамаарах 10011 субъект зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт зөрчлийн 94.7 хувийг цагдаагийн байгууллага, 0.4 хувийг мэргэжлийн хяналтын байгууллага, 0.3 хувийг татварын байгууллага, 0.2 хувийг гадаадын иргэн, харьяатын газар, 1.7 хувийг бусад эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэжээ. Эндээс харахад цагдаагийн байгууллага зөрчлийн дийлэнх хувийг дангаараа шийдвэрлэдэг бөгөөд үүнээс 90 гаруй хувийг нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хариуцлага хүлээлгэж байгаа талаар зарим судалгаанд дурдсан байна. Дараах судалгаанаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн үзүүлэлтийг харьцуулан үзье.

Аймаг, дүүрэг	Он					
	2019	2020	2021	2022	2023	2024
Улаанбаатар	1659618	1580126	1489089	2012191	2146107	2278228
Орон нутаг	548059	478221	432798	583283	744745	797214

Улс	2207677	2058347	1921887	2595474	2945490	3075442
-----	---------	---------	---------	---------	---------	---------

Хүснэгт 1. ЗХАБ-ын зөрчлийн статистик

Хүснэгтээс харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил жил бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин Тээврийн цагдаагийн албанаас зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон ажил зохион байгуулж, тайлан

мэдээндээ тусгаж байгаа боловч үр дүнг нь тооцож, нийгэмд үзүүлсэн ач холбогдлыг нь үнэлж, тооцсон судалгаа одоо хүртэл байхгүй байна.

Монгол Улсын тээврийн хэрэгслийн тоо болон жолоочийн тоон үзүүлэлтийг 2020 оны байдлаар дараах хүснэгтээр үзүүллээ.

Он	Тээврийн хэрэгслийн тоо	Өсөлт, бууралт	Жолоочийн тоо	Өсөлт, бууралт
2020	1137208	9	1335000	5.4
2019	1043028	7.4	1265544	4.7
2018	970880	7.8	1207690	4.6
2017	900127	6.9	1153621	5
2016	841537	-	1098638	-

Хүснэгт 2. Тээврийн хэрэгсэл, жолоочийн тоон үзүүлэлт

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд тээврийн хэрэгсэл 841537 байсан бол 2020 онд 1137208 буюу 35.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2016 онд жолоочийн тоо 1098638 байсан бол 2020 онд 1335000 байсан нь 21.5 хувиар өссөн байгаа нь зөрчлийн гаралтад шууд нөлөөлж байна.

Зам тээврийн осол, зөрчил, жолоочийн тоон үзүүлэлтийг харьцуулан үзэхэд жилээс жилд өссөн байгаа бөгөөд жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчил 97-оос дээш хувьтай байгаа нь монгол жолоочийн зан үйлийг судалж үзэх нь зүйтэй юм. Жолоочийн туршлага, жолоочийн зан үйл нь зайлшгүй нөлөөлдөг байна.

Туршлагатай жолоочийг шинэ жолоочтой харьцуулахад зам тээврийн осолд өртөх эрсдэл бага байдаг нь жолоодлогын туршлага нь болзошгүй аюулыг тодорхойлох, анхаарал хандуулж, нөөцийг үр дүнтэй хуваарилахад тусалдаг гэсэн үг юм (D. Lauro, R. Zhang, and X. Qu., 2016). Харин жолоодлогын туршлага дутмаг

шинэ жолоочийн хувьд зам тээврийн осолд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жолооны сургалтаар дадлагын хичээл ордог ч жолооч болсон эхний жилүүдэд алдаа гаргах магадлал өндөр хэвээр байдаг.

Жолоодлогын зан үйлийг тодорхойлох онолын гол үндэслэл нь “төлөвлөсөн зан үйлийн онол” буюу Theory of Planned Behaviour юм. Энэ нь жолоочийн сэтгэл зүйтэй шууд уялдаатай байх бөгөөд нь жолоодлогын зан үйлийг тайлбарлахад ашиглагдаж болохыг олон судалгаанууд харуулж байна.

Энэ онол нь зан үйлийг урьдчилан таамаглах зорилготой байдаг. Жишээлбэл, сэтгэл хөдлөлтэй тээврийн хэрэгсэл барих жолоодлого хийх нь жолоодлогыг аюултай зан үйлд хүргэдэг. Шинэхэн жолооч нар залуу зорчигчтой явахдаа анхаарал сарниулах эрсдэл өндөр байдаг.

Жолоочийн зөрчил гарахад сэтгэл зүй, жолоодлогын туршлага хэрхэн нөлөөлөхийг судалснаар түүний





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч болох юм. Өөрөөр хэлбэл, монгол жолоочийн зан төлөв, түүнд туршлага

хэрхэн нөлөөлөхийг судалж үзэх нь ач холбогдолтой юм.

Зөрчил гарахад нөлөөлөх хүчин зүйлс	Тайлбар
Зөрчил гаргагчийн хандлага	Тухайн хүний зан үйлийн үр дүн, гүйцэтгэлийн эерэг ба сөрөг үнэлгээний зэрэг.
Хотын соёл	Хувь хүний нийгмийн статусаа хадгалах эсвэл олж авахын тулд ашигладаг харилцаа холбоо, мэдээлэл, эрх ямбаны багц.
Хувь хүний зан чанар	Тухайн хүний тодорхой зан үйлийг байнга, байнга гаргахад хүргэдэг хүний шинж чанар.
Хүрээлэн буй орчин	Жолоочийг эрсдэлтэй үйлдэл хийхэд түлхэц болдог орчны хүчин зүйлс.
Амьдралын хэв маяг	Амьдрах арга зам эсвэл хэв маяг
Иргэний харьяалал	Хүн амьдарч буй нийгэмд харьяалагдах мэдрэмж.
Замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөх	Замын хөдөлгөөний дүрэм, журмыг дагаж мөрдөж, замын хөдөлгөөний өндөр эрсдэлтэй зан үйлээс зайлсхийхэд нөлөөлөх

Хүснэгт 3. Жолоочийн зөрчил гаргахад нөлөөлөх хүчин зүйл

Дээрх хүснэгтээс харахад жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил гаргахад жолоочийн хандлага, тухайн хүний хувийн зан чанар, хотын соёл, хүрээлэн буй орчин, амьдралын хэв маяг, замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөх зан үйл зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна. Мөн жолооч нарын замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд нөлөөлж буй хүчин зүйлийг харахад хувь хүний, нийгмийн, хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд нөлөөлж байна гэж судалгаандаа дурджээ. (Баасансүрэн, 2023)

Жолоочийн зан үйлийн талаарх судалгааг нэгтгэн авч үзвэл хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзэж болно. Жолоочийн зан үйл нь зөвхөн түүний жолоодох ур чадвар, хөдөлгөөнөөс гадна, тухайн хүнтэй холбоотой сэтгэл зүй, хандлага, орчны нөлөө гэх мэт олон хүчин зүйлсийн нийлбэр юм. Зарим үзүүлэлтүүдийг авч үзвэл:

1. Замын хөдөлгөөний дүрэм мөрдөх байдал. Энд жолоочийн замын хөдөлгөөний дүрэм, хязгаарлалт, гэрлэн дохиог хэр сайн мөрдөж байгаа эсэхийг шалгах нь зан үйлд нь томоохон үүрэгтэй. Монголд зарим жолооч нар

дүрэм зөрчиж, хурд хэтрүүлэх, зогсоолуудыг буруу ашиглах зэрэг асуудал байсаар байна.

2. Харилцаа ба хүндэтгэл. Жолооч нь явган зорчигчид, бусад тээврийн хэрэгслийн жолоочтой хэрхэн харилцаж байгааг харахад хүндэтгэлгүй, түрэмгий хандаж, бусадтай хэрүүл маргаан өдүүлж байгаа нь харагддаг.

3. Тэвчээр, сэтгэл хөдлөл. Зам хөдөлгөөний ачаалалтай үед хэр тэвчээртэй байж, аюулгүй байдлыг хадгалж, тээврийн хэрэгслээ жолоодож байгаа нь харагддаг. Хэт түрэмгий хандлага, сэтгэл хөдлөлийн хяналтгүй байдал нь осол аваар, эрсдэлд хүргэх боломжтой.

4. Хурд ба аюулгүй байдал: Жолоочийн хурд хэтрүүлэх, аюулгүй байдлаа хангахгүй байх нь түгээмэл асуудал болж байна. Мөн зорчигчдыг хамгаалах, бүс хэрэглэх, замын нөхцөлд тохирсон хурдтай явах нь чухал.

5. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах. Машиныг цэвэрлэх, эвдрэлгүй байлгах, зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглах нь жолоочийн хариуцлагатай

зан үйл юм. Зарим жолооч нар тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангахгүй байгаа эрсдэлд оруулж байдаг.

6. Эрсдэлтэй нөхцөлд шийдвэр гаргах чадвар. Жолооч замын нөхцөл, цаг агаар, бусад хүчин зүйлсээс хамаарч хэр хурдан, зөв шийдвэр гаргаж, аюулгүй байдлаа хангах нь түүний жолоодлогын ур чадвартай шууд хологдож байна.

7. Сэрэмжтэй байдал. Замын хөдөлгөөнд оролцоходоо жолооч сэрэмжтэй, орчныг анхааралтай ажиглаж байгаа нь түүний зан үйлд нөлөөлнө. Сэрэмжтэй байдал нь осол аваар, бусад эрсдэлээс зайлсхийх боломжийг олгодог.

Эдгээр бүх үзүүлэлтүүд нь монгол жолоочийн зан үйлд нөлөөлөх гол хүчин зүйлс юм. Жолоочийн зан үйл нь зөвхөн техникийн ур чадвар төдийгүй, хүний сэтгэл зүй, хандлага, хариуцлагын хэмжээгээр ч тодорхойлогддог. Тиймээс, жолоочийн зан үйлийг дүгнэхдээ эдгээр бүх хүчин зүйлсийг анхаарах нь зүйтэй.

Дүгнэлт

Жолоочийн зан үйлийг харьцуулан авч үзэхэд англи хэлнээ “driver behavior” гэсэн агуулгын хүрээнд судлагддаг бөгөөд **зан үйл** (behavior) нь тухайн хүний хийх үйлдэл, хөдлөх хөдөлгөөн, араншин, амьдралын хэв маяг, бусадтай харьцах арга зэргийн нийлбэр юм. Хүний зан үйл нь аливаа орчинд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, ямар замаар асуудал шийдэх зэрэгт илэрдэг. Харин зан **төлөв** (personality) нь тухайн хүний байнгын, тогтвортой сэтгэл хөдлөл, хандлага, сэтгэлгээний хэв маягийг илэрхийлдэг. Энэ нь хүний ерөнхий шинж чанар, олон нийттэй харьцах арга, өөрийгөө илэрхийлэх хэв маяг зэргээс бүрддэг.

Монгол улсад жолоочийн зан үйлийг судалсан байдлыг дүгнэж хэлэхэд энэ талаар судалсан бүтээл ховор байх бөгөөд энэ чиглэлийн судалгааг эхлүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Учир нь зам тээврийн осол, зөрчлийн гаралт жолоочийн буруутай үйлдлээс шууд шалтгаалж байгаа талаар цагдаагийн байгууллагаас мэдээлсээр байна. Тиймээс жолоочийн буруутай үйлдлийн гол шалтгааныг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах арга замыг оновчтой авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Монголд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх бүтээлүүдийг тоймлон үзэхэд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэсэн эрх зүйн зохицуулалт талаас нь судалсан бүтээлүүд. Үүнд эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, дүрэм зөрчсөн жолооч нарт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар судалжээ.

- Жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчил, гэмт хэргийг бууруулахтай холбоотой бүтээлүүд. Энд жолоочийн мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай, энэ чиглэлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулах, жолоочийн соёлыг дээшлүүлэх нь чухал гэж дүгнэсэн байна.

- Зам тээврийн осол, зөрчил, гэмт хэрэг гарахад замын нөхцөл байдал, хүрээлэн буй орчин нөлөөлж байгаа талаар судалсан бүтээлүүд. Энэ хэсэгт Монгол Улсын авто зам, замын байгууламж, хүрээлэн буй орчин, нөхцөлд дүн шинжилгээ хийж, түүнд холбогдох стандарт, норм, хэм хэмжээ бүрэн хэрэгжихгүй байгаа талаар дүгнэжээ.





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САНГАА
MONGOLIAN STATE COURT

• Тээврийн хэрэгсэл, техникийн бүрэн бүтэн байдал замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй талаар судалсан бүтээлүүд. Тээврийн хэрэгслийн техник үйл ажиллагааны доголдол нь осол шууд нөлөөлөх талаар дурдаж, жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх талаар дүгнэсэн байна.

Эдгээр бүтээлүүдийг тоймлон судалж үзэхэд жолоочийн зан үйлийн талаарх судалгааг манай улсад хөгжүүлэх, цогц байдлаар судлах, тухайлбал, дижитал технологиос цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Монгол жолоочийн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Мөн жолоочийн соёлыг төлөвшүүлэх, нийгмийн хандлагыг сайжруулахад чиглэх нь зүйтэй юм.

Ашигласан материал

- Abdelrahman, A. E., Abu-Ali, N., & Hassanein, H. (2020). Robust data-driven framework for driver behavior profiling using supervised machine learning. *IEEE TRANSACTIONS ON INTELLIGENT TRANSPORTATION SYSTEMS*, 23. <https://doi.org/10.1109/TITS.2020.3035700>
- Advanced Driving Assistance Systems (ADAS)*. (2025 оны January 27). <https://www.valeo.com/>: <https://www.valeo.com/en/assistance-systems/-ээс> Гаргасан
- Awan, H., Pirdavani, A., Westhof, S., Adnan, M., & Brijs, T. (2019). Impact of perceptual countermeasures on driving behavior at curves using driving simulator. *Traffic Injury Prevention*, 20(1), 93–99. <https://doi.org/doi.org/10.1080/15389588.2018.1532568>
- Bahadoor, K., & Hosein, P. (2016). Application for the Detection of Dangerous Driving and an Associated Gamification Framework. *2016 IEEE 4th International Conference on Future Internet of Things and Cloud Workshops (FiCloudW)*. IEEE. <https://doi.org/10.1109/W-FiCloud.2016.63>
- D. Lauro, R. Zhang, and X. Qu. (2016). “The role of personality traits and driving experience in self-reported risky driving behaviors and accident risk among Chinese drivers. *Accident Analysis & Prevention*, 99, 228–235. <https://doi.org/doi.org/10.1016/j.aap.2016.12.009>
- Kumar, N., Ankit, K., & Pathani, A. (2017). Intelligent transportation system: Review paper. <https://www.ijser.org/>.
- Peng, Y., Li, C., & Wang, K. (2020). Examining imbalanced classification algorithms in predicting real-time traffic crash risk. *Accident Analysis & Prevention*, Volume 144.
- Soukaina, B., Nawal, S., & Faouzia, B. (2023). Driver Behavior Classification: A Systematic. *IEEE Access*, 27.
- Soultana, A., Benabbou, F., & Sael, N. (2019). Context-awareness in the smart car. *SCA '19: Proceedings of the 4th International Conference on Smart City Applicatio*. Casablanca: Association for Computing Machinery. <https://doi.org/10.1145/3368756.336901>
- Wang, C., Musaev, A., Sheinidashtegol, P., & Atkison, T. (2019). Towards detection of abnormal vehicle behavior using traffic cameras. *Big Data – BigData 2019* (pp. pp 125–



- 136). San Diego: Springer.
https://doi.org/10.1007/978-3-030-23551-2_9
- WHO. (2018). *Global Status Report on Road Safety*. Geneva, Switzerland,: World Health Organization.
- Анхбаяр, Т. (2022). *Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын шинжилгээ*. Улаанбаатар., .
- Баасансүрэн, Д. (2023). *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ*. Улаанбаатар., .
- Батбаяр, Б. (2017). *Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал*. Улаанбаатар., .
- Батболд, Ч. (2015). *Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад техник хэрэгслийг ашиглах нь*. Улаанбаатар., .
- Батсайхан, Б., & Дэлгэржав, М. (2013). *Ерөнхий сэтгэл судлал* (218 хян.). Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Баттөмөр, Т. (2008). *Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих захиргааны хяналт*. Улаанбаатар., .
- Ганхуяг, П. (2015). *Зам тээврийн хэрэг, ослын гаралтыг бууруулах ажлын удирдлага, зохион байгуулалт*. Улаанбаатар., .
- Гомбосүрэнжав, Д. (2017). *Тууш замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал*. Улаанбаатар., .
- Гэрэлмаа, Ц. (2014). *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал*. Улаанбаатар., .
- Д.Мөнгөн. (2020). *Жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, хэргийг бууруулах арга зам*. Улаанбаатар., .
- Доржжав, Д. (2005). *Сэтгэл зүйд өөрөө суралцах нь*. Улаанбаатар: Эдмон ХХК.
- Дүгэрээ, Д., & Каукен, Ж. (1992). *Замын хөдөлгөөний аюулгүйн үндэс*. Улаанбаатар., .
- Жанцан, С. (2024). *Хууль зүйн сэтгэл судлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Жаргал, Г. (2018). *Замын хөдөлгөөний аюулгүй байдалд жолоочийн оролцоо*. Улаанбаатар., .
- Жаргалсайхан, Ч. (2002). *Жолоодлогын тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх ажиллагааг төгөлдөржүүлэх нь*. Улаанбаатар., .
- Занашир, Т. (1997). *Аюултай цэгүүдийг тооцож, хөдөлгөөнийг тооцоолох нь*. Улаанбаатар., .
- (2021). *Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга*. . Улаанбаатар., .
- Мягмарсүрэн, Ц. (2017). *Зам тээврийн осол хэргийн шалтгаан, түүний эрсдэлийн удирдлага*. Улаанбаатар., .
- Нямдорж, Д. (2009). *Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх криминологийн шинж чанар*. *Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл*. . Москва .
- Оюундалай, Н., & Балжинням, Б. (2017). *Харилцааны сэтгэл судлал*. Улаанбаатар: Содпресс ХХК.
- Оюундалай, Ч., Бэх, Ч., & Мягмарсүрэн, Д. (2019). *Жолоочийн сэтгэл зүй*. УБ., : Сод пресс ХХк.
- Т.Анхбаяр. (2022). *Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэж буй сургалтын шинжилгээ*. Улаанбаатар., .



МОНГОЛ УЛСЫН
ДЭГДСЭН СУРГАЛ

ТЦА. (2024). *Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл*. Улаанбаатар: Тээврийн цагдаагийн алба.

Чинзориг, Ц. (2017). *Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэлээр нутгын захиргааны байгууллагаас*

гаргасан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ. Улаанбаатар., .

Энхболд, А. (2008). *Замын хөдөлгөөний аюулгүй байдал*. Улаанбаатар.,.

Эрдэнэхуяг, Б. (2017). *Замын хөдөлгөөний нөхцөл байдал зам тээврийн осолд нөлөөлөх хүчин зүйл болох*. Улаанбаатар., .